



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/340

Есөнбулаг


Хувийн хэвшил, Төрийн бус  
байгууллагаар гүйцэтгүүлсэн ажилд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4 хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь :

1.Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах, Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, аймгийн Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт цаг үеийн шинжтэй мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх сурталчлах ажлыг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зорилгоор "Малчин удмын хийморь" ХХК-тай байгуулсан гэрээний ажлын хөлс 5,000,000 (таван сая) төгрөгийг төрийн өмнөөс гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

